



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/100

Арвайхээр

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн II түвшин (шар)-д шилжсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “б”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн “Түр журам, заавар батлах тухай” 20 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 07 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хот, эрсдэлтэй бүс нутгаас ирэх иргэдийг PCR шинжилгээний хариуг үндэслэн Тарнын хяналтын цэгт түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч сөрөг гарсан тохиолдолд бүртгэл, хяналтын системд бүртгэн аймгийн нутаг дэвсгэрт оруулах, хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2.Дээрх иргэдийг гэр бүлийн гишүүдийн хамт 7 хоногийн хугацаанд гэрийн ажиглалтад халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Хужирт суманд үйл ажиллагаа явуулж буй рашаан сувиллуудыг ажиллуулах, үйлчлүүлж байгаа иргэдийг бүртгэлжүүлж, эрсдэлтэй бүс нутгаас ирсэн иргэдийн PCR шинжилгээг үндэслэн түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч, ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Хужирт сумын Засаг дарга (Т.Баярмөнх) нарт үүрэг болгосугай.

4.Аж ахуйн нэгж, төрийн байгууллагууд бүртгэл хяналтын системийг нэвтрүүлэн, бүртгэл хийж, хяналт тавьж ажиллахыг байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100218

D:My Doc. Zahiramj. Zasag darga